



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2020.08.24-2020.08.28



Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-аас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ТОЙМ

2020 оны 8-р сарын 24-28 хооронд

Монголын Хөрөнгийн Биржийн бүх мэдээллийг mse.mn-с авсан ба бусад мэдээллийн эх сурвалжийг дор бүр нь харуулсан болно.

Арилжааны товч мэдээ

Нийт арилжааны дүн(сая төгрөг)	340.5
Зах зээлийн үнэлгээ(сая төгрөг)	2,593,778.7
Хэлцлийн тоо	1,107
Арилжигдсан үнэт цаасны тоо	53

INDEX	Хаалт	Өөрчлөлт
TOP-20 INDEX	17,040.14	-0.61% ▼
MSE-A INDEX	8,280.28	-0.11% ▼
MSE-B INDEX	7,382.43	+0.32% ▲

Хамгийн өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Талх Чихэр	14,700	+22.09% ▲
Улсын Их Дэлгүүр	1,399	+16.48% ▲
Тээвэр-ачлал	1,058	+15.00% ▲
Э-транс Ложистикс	143	+14.40% ▲
Хишиг Уул	682	+13.28% ▲

Хамгийн уналттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Би Ди Сек	716	-14.86% ▼
Дархан Зочид Буудал	125	-14.73% ▼
Материалимпекс	7,190	-14.40% ▼
Ард Санхүүгийн Нэгдэл	1,020	-9.73% ▼
Нако Түлш	28	-6.66% ▼



Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компани	Төгрөг
Бидисек ҮЦК	614,991,250
Мирэ Эссет Секьюритис Монгол	210,308,089
Ард Секюритиз ҮЦК	121,738,631
Алекс Капитал ҮЦК	78,646,629
Гаули ҮЦК	73,584,247

Идэвхтэй арилжсан хувьцаа	Төгрөг
АПУ	92,886,240
Говь	67,579,204
Ард Даатгал	41,892,337
Мандал Даатгал	34,917,302
Лэндмн Ббсб	20,618,291

Энэ долоо хоногт нийт 340.5 сая төгрөгийн арилжаа хийгдсэн ба нийт 1,107 хэлцэл хийгдэж 53 компанийн хувьцаа арилжаанд оролцсон байна.

Монголын Хөрөнгийн Биржийн Топ-20 индекс 17,040-д хүрч хаагдсан ба нийт зах зээлийн үнэлгээ 2.594 их наяд төгрөгийн үнэлгээтэй боллоо.

Талх Чихэр хувьцаат компанийн хувьцаа 14,700 хүрч энэ долоо хоногт 22.09% өсөж хаагдлаа. Харин Би Ди Сек хувьцаат компанийн хувьцаа 716 хүрч энэ долоо хоногт -14.86%-р буурч хаагдлаа



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

2020 оны 8-р сарын 24-28 хооронд

Монголын Хөрөнгийн Биржийн бүх мэдээллийг mse.mn-с авсан ба бусад мэдээллийн эх сурвалжийг дор бүр нь харуулсан болно.

“ТАВАНТОЛГОЙ”-ИЙН ҮНЭЛГЭЭ +10.3 ТЭРБУМААР ӨСЧ, “АПУ”-ИЙНХ -8.9 ТЭРБУМААР БУУРЛАА

Дотоодын хөрөнгийн зах зээлийн топ компаниуд болох Тавантолгой /MSE:TTL/ болон АПУ /MSE:APU/ компаниудын зах зээлийн үнэлгээний өсөлт, бууралтаараа тэргүүлсэн өдөр байлаа.

Ингээд энэ өдрийн ТОП-3 өсөлт бууралтын үзүүлэлтийг хүргэж байна.

ЗЗҮнэлгээ нь өссөн:

1. Тавантолгой /MSE:TTL/ : +10.3 тэр.₮-өөр өсч 315.7 тэр.₮
2. Ард санхүүгийн нэгдэл /MSE:AARD/ : +1.9 тэр.₮-өөр өсч 31.5 тэр.₮
3. Ариг гал /MSE:EER/ : +1.0 тэр.₮-өөр өсч 10.4 тэр.₮

ЗЗҮнэлгээ нь буурсан:


1. АПУ /MSE:APU/ : -8.9 тэр.₮-өөр буурч 626.7 тэр.₮
2. Мик холдинг /MSE:MIK/ : -3.9 тэр.₮-өөр буурч 265.1 тэр.₮
3. Улсын их дэлгүүр /MSE:UID/ : -2.6 тэр.₮-өөр буурч 49.8 тэр.₮. (marketinfo.mn)

1995 ОНООС ХОЙШ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХАД 3.4 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН АРИЛЖАА ЯВАГДЖЭЭ

2018.08.28-ны энэ өдөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хувьд түүхэн чухал өдөр тохиож байна.

Тодруулбал, иргэд өмч хувьчлалын үед цэнхэр, ягаан тасалбараар авсан хувьцаагаа бусдад худалдах, бусдаас хувьцаа худалдан авах боломжтой болсон ба өөрөөр хэлбэл ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА эхэлсэн өдөр юм.

1995 оноос хойш хөрөнгийн зах дээр нийтдээ 2.9 тэрбум ширхэг үнэт цаас арилжигдаж, 3.4 их наяд төгрөгийн мөнгөн дүнтэй арилжаа явагджээ. (marketinfo.mn)



“ЖЕНКО ТУР БЮРО”-ИЙН ХУВЬЦААНД СҮҮЛД ХИЙГДСЭН 5-BLOCK TRADE

Даваа гарагийн арилжаагаар Женко тур бюро /MSE:JTB/-ийн хувьцаан дээр Block trade хийгдсэн байна.

Энэ удаа тус компанийн 5.26 сая ширхэг буюу компанийн 6.6%-тай тэнцэх хувьцаа арилжигдсан бөгөөд хувьцаа нэг бүр нь 95₮-ийн ханш дээр зарагдав. Хэлцэлийн нийт үнийн дүн 499.9 сая төгрөг болжээ.

Женко тур бюро /MSE:JTB/-ийн хувьцаанд хийгдэж байсан томоохон арилжааны мэдээллийг доор харуулав. (marketinfo.mn)

ЖЕНКО ТУР БЮРО-ИЙН ХУВЬЦААНД СҮҮЛД ХИЙГДСЭН 5-BLOCK TRADE

Тус компани болон бусад ХК-ийн талаарх дэлгэрэнгүй хэлцэлүүдийг data.marketinfo.mn-ээс үзэж болно.

Огноо	Ширхэг	Зарагдсан үнэ	Үнийн дүн
2017.01.30	15,053,101	54₮	812,867,454₮
2018.10.11	10,353,374	70₮	724,736,180₮
2020.08.12	3,571,596	95₮	339,301,620₮
2020.08.21	2,631,582	95₮	250,000,290₮
2020.08.31	5,263,157	95₮	499,999,915₮

www.marketinfo.mn